

Тусгай зөвшөөрөл

Цахим гарын үсгийн тухай хуулийн 26 дугаар зүйл, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 8, 9, 9¹ дүгээр зүйл, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.1, 8.2 дугаар зүйлийн 8.1, 8.2-т тус тус заасны дагуу заасны дагуу Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх болон Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх энгийн зөвшөөрлийг тус тус олгож байна.

1. Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

Зөвшөөрлийн тухай хууль

4.1 дүгээр зүйл. Зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага

1.Энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн үйл ажиллагааг эрхлэх этгээд дараах нийтлэг нөхцөл, шаардлагыг хангасан байна:

1.1.иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх;

1.2.хуульд заасан бол мэргэжил, мэргэшлийн шалгалтад тэнцсэн, зохих дүгнэлт гаргуулсан байх;

1.3.татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх.

Бүрдүүлэх материал

Цахим гарын үсгийн тухай хууль

25 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

25.1.Тусгай зөвшөөрөл хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлж, цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүсэлт гаргана:

25.1.1.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

25.1.2.гэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журам;

25.1.3.харилцагч банкны мэдэгдэл;

25.1.4.баталгаажуулсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт;

25.1.5.кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэсэн талаарх тайлан;

25.1.6.олон улсын мэргэжлийн холбоо, стандартын байгууллагын стандартын шаардлагыг хангасан талаарх тайлан;

25.1.7.өөр төрлийн зөвшөөрөл эзэмшдэг бол зөвшөөрлийн хуулбар.

Гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

17 дугаар зүйл.Гэрчилгээг түдгэлзүүлэх, сэргээх

17.1.Гэрчилгээжүүлэх байгууллага дараах тохиолдолд гэрчилгээг түдгэлзүүлнэ:

17.1.1.гэрчилгээ эзэмшигч гэрчилгээг түдгэлзүүлэх талаар бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүсэлт гаргасан;

17.1.2.гэрчилгээнд тусгасан мэдээлэл алдаатай, эсхүл хувийн түлхүүрийн нууцлал алдагдсан гэж гэрчилгээжүүлэх байгууллага үзсэн;

17.1.3.хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрчилгээг түдгэлзүүлэх талаар эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;

17.1.4.эрх зүйн чадамжгүй нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.

17.2.Гэрчилгээжүүлэх байгууллага гэрчилгээг түдгэлзүүлсэн тухай гэрчилгээ эзэмшигчид даруй мэдэгдэнэ.

17.3.Гэрчилгээжүүлэх байгууллага хойшлуулшгүй тохиолдолд гэрчилгээ эзэмшигчийг таньсны үндсэн дээр гэрчилгээ эзэмшигчийг энэ хуулийн 17.1.1-д зааснаас бусад хэлбэрээр гэрчилгээг түдгэлзүүлэх боломжоор хангана.

17.4.Энэ хуулийн 17.1.1-д заасан үндэслэлээр гэрчилгээг түдгэлзүүлэх талаар хүсэлт гаргасан гэрчилгээг сэргээх тухай хүсэлт гаргаснаар гэрчилгээг гэрчилгээжүүлэх байгууллага даруй сэргээнэ.

17.5.Энэ хуулийн 17.1.1-д заасан үндэслэлээр гэрчилгээг түдгэлзүүлэх хугацааг гэрчилгээ эзэмшигч өөрөө тогтоох бөгөөд уг хугацаа нь энэ хуулийн 11.1-д заасан хугацаанаас хэтрэхгүй байна.

17.6.Энэ хуулийн 17.1.2, 17.1.3-т заасны дагуу түдгэлзүүлсэн шалтгаан арилснаар гэрчилгээжүүлэх байгууллага гэрчилгээг сэргээж, энэ тухай гэрчилгээ эзэмшигчид даруй мэдэгдэнэ.

18 дугаар зүйл.Гэрчилгээг хүчингүй болгох

18.1.Гэрчилгээжүүлэх байгууллага гэрчилгээг дараах үндэслэлээр хүчингүй болгоно:

18.1.1.гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дууссан;

18.1.2.хувийн түлхүүр задарсан, задрах боломж бүрдсэн тухай гэрчилгээ эзэмшигч мэдэгдэж хүсэлт гаргасан;

18.1.3.гэрчилгээ эзэмшигч гэрчилгээг хүчингүй болгуулахаар бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүсэлт гаргасан;

18.1.4.гэрчилгээ эзэмшигч хүн нас барсан, эсхүл хүнийг нас барсанд тооцсон, хуулийн этгээд татан буугдсан;

18.1.5.гэрчилгээг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

18.1.6.гэрчилгээ эзэмшигч энэ хуулийн 14.3-т заасан үүргээ биелүүлээгүй.

18.2.Гэрчилгээний хүчинтэй байх хугацаа дуусаагүй нь гэрчилгээг хүчингүй болгоход нөлөөлөхгүй.

Төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль

30.1.1.тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 10 000 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад 5 000 000 төгрөг,

Дансны мэдээлэл

Төрийн сан: MN530090100900067400

Дансны нэр: ЦХИХХ яам н.с

2. Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөл

Зөвшөөрлийн тухай хууль

4.1 дүгээр зүйл. Зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага

1.Энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн үйл ажиллагааг эрхлэх этгээд дараах нийтлэг нөхцөл, шаардлагыг хангасан байна:

1.1.иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх;

1.2.хуульд заасан бол мэргэжил, мэргэшлийн шалгалтад тэнцсэн, зохих дүгнэлт гаргуулсан байх;

1.3.татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх.

Кибер аюулгүй байдлын тухай хууль

9.2.Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

9.2.1.олон улсын мэргэжлийн холбоо, стандартын байгууллага, эсхүл түүнтэй дүйцэхүйц байгууллагаас олгосон мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хүчин төгөлдөр гэрчилгээ бүхий орон тооны ажилтантай байх;

9.2.2.энэ хуулийн 9.2.1-д заасан ажилтан ижил төрлийн аудит хийх эрх бүхий бусад хуулийн этгээдэд зэрэгцсэн гэрээгээр ажилладаггүй байх;

9.2.3.хуульд заасан бусад шаардлага.

9¹ дүгээр зүйл.Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх

9¹.2.Зөвшөөрөл хүсэгч өргөдөлд зөвшөөрлийн ангилал, түүнд холбогдох үйл ажиллагааны зорилго, үндэслэлийг тодорхой тусгах бөгөөд дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:

9¹.2.1.зөвшөөрөлд тавигдах хуульд заасан нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичиг;

9¹.2.2.энэ хуулийн 8.2, 9.2, 9.3-т заасан нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичиг.

Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/74 дүгээр тушаалын хавсралтаар баталсан Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам

3 дугаар зүйл

3.3. Аудит хийх зөвшөөрөл хүсэгч нь дараах баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад хүргүүлнэ:

3.3.1.үйл ажиллагаа явуулах эрх хүссэн хүсэлт (албан бичгээр);

3.3.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.3.3. орон тооны ажилтны танилцуулга, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа, олон улсын мэргэжлийн холбоо, стандартын байгууллага, эсхүл түүнтэй дүйцэхүйц байгууллагаас олгосон хүчин төгөлдөр гэрчилгээний хуулбар;

3.3.4. энэ журмын 3.2-т заасан шаардлагыг хангаж буйг нотлох бусад баримт бичиг.

3.4. Бүртгэх байгууллага зөвшөөрөл хүсэгчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2-т заасан хугацаанд багтаан шийдвэрлэнэ.

3.5. Бүртгэх байгууллага энэ журмын 3.3-т заасан баримт бичгийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн системээр дамжуулан шалгана.

3.6. Энэ журмын 3.3-т заасан шаардлагыг хангаж буйг магадалж ирүүлсэн баримт бичгийн эх хувийг шаардаж болно.

3. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх зөвшөөрөл

Зөвшөөрлийн тухай хууль

4.1 дүгээр зүйл. Зөвшөөрөл хүсэгч, эзэмшигчид тавигдах нийтлэг шаардлага

1. Энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийн үйл ажиллагааг эрхлэх этгээд дараах нийтлэг нөхцөл, шаардлагыг хангасан байна:

1.1. иргэний эрх зүйн бүрэн чадамжтай байх;

1.2. хуульд заасан бол мэргэжил, мэргэшлийн шалгалтад тэнцсэн, зохих дүгнэлт гаргуулсан байх;

1.3. татвар төлөгчөөр бүртгүүлсэн байх.

Кибер аюулгүй байдлын тухай хууль

9¹ дүгээр зүйл. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх хуулийн этгээдийг бүртгэх

9¹.2. Зөвшөөрөл хүсэгч өргөдөлд зөвшөөрлийн ангилал, түүнд холбогдох үйл ажиллагааны зорилго, үндэслэлийг тодорхой тусгах бөгөөд дараах баримт бичгийг өргөдөлд хавсаргана:

9¹.2.1. зөвшөөрөлд тавигдах хуульд заасан нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичиг;

9¹.2.2. энэ хуулийн 8.2, 9.2, 9.3-т заасан нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичиг.

Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

Зөвшөөрлийн тухай хууль

6.1 дүгээр зүйл. Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх

1.Эрх бүхий этгээд дараах тохиолдолд зөвшөөрлийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

- 1.1.зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;
- 1.2.хуульд заасан мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл буруу гаргасан;
- 1.3.зөвшөөрөл олгосноос хойш хоёр жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон.

2.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 1-д заасан үндэслэл байгаа тухай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэж, мэдэгдлийг хүргүүлсэн он, сар, өдрийг тэмдэглэлд тусгана.

3.Энэ зүйлийн 2-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш зөвшөөрөл эзэмшигч ажлын 10 өдрийн дотор зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбар, холбогдох баримт бичгийг эрх бүхий этгээдэд ирүүлээгүй бол зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

4.Эрх бүхий этгээд зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай шийдвэрийн талаар зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд ажлын хоёр өдрийн дотор бичгээр, эсхүл энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 10-т заасан цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

5.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 1-д заасан үндэслэл, нөхцөл, шаардлага арилсан тохиолдолд зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн зөвшөөрлийг сэргээнэ.

6.2 дугаар зүйл.Зөвшөөрлийг хүчингүй болгох

1.Зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:

- 1.1.зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;
- 1.2.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй;
- 1.3.зөвшөөрөл эзэмшигч нийтийн эрх ашиг, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчин, үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлсэн, их хэмжээний хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;
- 1.4.зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчсөн;
- 1.5.зөвшөөрөл, түүнийг баталгаажуулсан баримт бичгийг хуульд зааснаас бусад тохиолдолд худалдсан, бэлэглэсэн, барьцаалсан болон бусад хэлбэрээр шилжүүлсэн;
- 1.6.зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;
- 1.7.зөвшөөрөл эзэмшигч иргэн бол иргэний эрх зүйн бүрэн чадамжгүйд тооцогдсон, хуулийн этгээд бол дампуурсан, эсхүл татан буугдсан;
- 1.8.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.6-д заасан хугацаанд улсын тэмдэгтийн хураамжийг төлөөгүй.
- 1.9.хуульд заасан бусад.

6.3 дугаар зүйл.Зөвшөөрлийг хүчингүй болгох журам

- 1.Эрх бүхий этгээд зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл байгаа тухай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэж, мэдэгдлийг хүргүүлсэн он, сар, өдрийг тэмдэглэлд тусгана.
- 2.Энэ зүйлийн 1-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш зөвшөөрөл эзэмшигч 30 хоногийн дотор зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбар, холбогдох баримт бичгийг эрх бүхий этгээдэд ирүүлээгүй бол уг хугацаа дууссанаас хойш ажлын 10 өдрийн дотор зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэнэ.
- 3.Зөвшөөрөл эзэмшигч энэ зүйлийн 2-т заасан хугацаанд тайлбар өгөөгүй, энэ зүйлийн 1-д заасан мэдэгдэлд гомдол гаргаагүй бол зөвшөөрөл хүчингүй болгох үндэслэлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 4.Эрх бүхий этгээд зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд ажлын хоёр өдрийн дотор бичгээр, эсхүл энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 10-т заасан цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

----o0o----